

Л.БАДАРЧ ДӨЧ, ТАВИАД ОНЫ ШОГ ХОШИН НИЙТЛЭЛИЙН
ТОМООХОН ТӨЛӨӨЛӨГЧ МӨН

Н.Ариунзаяа*

* БНЭУ-ын Шинэ Дели хотын Олон нийтийн харилцааны дээд сургуулийн сонсогч, Сэтгүүл зүйн доктор (Ph.D)

Түлхүүр үг: авьяас, нэрт төлөөлөгч, "хөх зодогт", туурвил, ёгт үлгэр, уран зохиол, нийтлэл

Өнгөрсөн зуун жилд Монголын сэтгүүл зүйд мэдлэг ухаанаа зориулсан хэдэн мянган хүний нэрийг жагсааж болох боловч тэдний олонх нь түүхийн тоосонд дарагдан, аажмаар мартагдаж, цөөн хэдийнх нь нэр, мөр хоёр бичиг номд дурайж үлдсэн байх юм. Энэ нь жам ёсны хэрэг байх. Гэвч зуу зуун жил өнгөрсөн ч мартаж боломгүй зарим нэг онцгой хүнийг бид хааяа өнгөрсөн түүхийн тоосон дундаас олж харахгүй өнгөрөх нь сэтгүүл зүйн туурвилын түүхэн туршлагад хоосон зай үлдээх муу үр дагавартай юм.

Монголын нийтлэлийн түүхэнд мартагдах учиргүй атлаа мартагдаж орхигдсон авьяастны нэг бол шинэ үеийн уран зохиолын нэрт төлөөлөгч Лувсандашийн Бадарч билээ. Л.Бадарч 1919 онд төрж уран бүтээлийнхээ ид цэцэглэлтийн үед буюу дөнгөж дөчин нэгэн насандаа хорвоогоос хальжээ. Гэвч хүний амьдралын үнэ цэнг хэд наслав гэдгээр нь бус, юу бүтээв гэдгээр нь хэмжих ёсыг баримталвал

тэрээр нэгэн насныхаа амьдралыг учир утгатай өнгөрүүлсэн сод авьяастны нэг байлаа.

Л.Бадарч бол юуны өмнө Монголын шинэ үеийн уран зохиолд хамгийн их үгүйлэгдэж байсан шог, хошин зүйлийг хөгжүүлэхэд бүтээлч хөдөлмөрөө зориулсан уран бүтээлч юм. «Хөх зодогт», «Дурсгалт зураг», «Авхайн морь», «Баярын хундага», «Баатарлаг явдал», «Сайн буурал» зэрэг өгүүллэг, «Хэрээ, зараа хоёр», «Толь Гэндэнгийн үг», «Баавгай», «Хазгар илжигний түүх», «Америкийн зүүд ба алтан загасны үлгэр», «Долоон оготнын домог» зэрэг ёгт үлгэр, улс төрийн шогоос эхлээд Монголын уран зохиолын сан хөмрөгт эрдэнийн шигтгээ болж орсон алдарт «Хүжийн гал» өгүүллэг хүртэл олон арван бүтээл туурвисан зохиолч юм. Түүний уран зохиолын үйл хэргийг судалж, сурвалжлах нь утга зохиол судлаачдын үүрэг. Чамлахааргүй судалсан зүйл ч бий байх. Харин нийтлэл-уран сайхны бүтээлийг нь зориуд судалсан зүйл нэн ховор юм. Миний бие энэ удаад түүний авьяаслаг нийтлэлч, дөч, тавиад оны шог, хошин нийтлэлийн томоохон төлөөлөгч болох тухай цухас тэмдэглэхийг хүслээ.

Л.Бадарчийн уран бүтээлийг ерөнхийд нь авч үзвэл уран зохиолын богино төрөл, тухайлбал өгүүллэг, шүлэг, хошин өгүүллэг, шог шүлэг, ёгт үлгэр зонхилж байгаа бол, нийтлэлийн зүйлүүдэд нь найруулал, шог найруулал, улс төрийн шог голлож байна. Түүний туурвилд байгаа нэг өвөрмөц онцлог бол зохиол бүтээлээ уран зохиол, нийтлэлийн зааг дээр биежүүлдэг явдал юм. Энэ нь бүтээл туурвилдаа урлах эрдмийн зэрэгцээ цаг үеэ тусгах, хөгжил дэвшилд тус болох, дутагдал хоцрогдлыг засах дайчин давшингуй санааг эрхэмлэдэгтэй нь холбоотой байна. Тиймээс ч бүтээлүүддээ ямагт амьдрал ахуйн тулгамдсан асуудлуудыг тусгасан байдаг. Түүний өгүүллэгүүдэд буух мөр, буцах хаяггүй төлөөллийн дүр гардгийг нь эс тооцвол найруулалтай төстэй байдаг. Жишээ нь «Чулуун арслангийн хэрэг» өгүүллэгт соёлын өвийг хадгалж хамгаалах, «Дэндүү Дэндэв» өгүүллэгт нийгмийн өмч хөрөнгийг хайр гамтай эдлэх, «Хог өвс» өгүүллэгт малд хүчит тэжээл бэлтгэх тухай гарч байгаа нь уран зохиолын гэхээсээ илүү нийтлэлийн сэдэв гэмээр байдаг. Ерөөсөө нийгмийн амьдралд хурцаар тавигдаж байгаа асуудлыг хэн нэг баатрын дүрээр, уран зохиолын аргаар дэвшүүлэн тавьж, түүгээрээ нийгэмд шууд ханддаг нь Л.Бадарчийн өгүүллэгүүдийн өвөрмөц барил юм.

Л. Бадарчийн өгүүллэгүүд амьдралаас урган гарсан чухал асуудлыг хөндөж, нийгмийн хөгжлийг түргэсгэхэд саад болж байгаа дутагдлыг хуучин, шинийн зөрчил дундаас товойлгон үзүүлдгээрээ уншигчдад нөлөөлөх чадвар сайтай байдаг онцлогтой юм. Утга зохиолын шүүмжлэгч Д.Цэнд энэ тухай өгүүлэхдээ: «Он жилүүд улиран орчиж хайрт эх орон нь

хатан бат хүчирхэг чадалтай болж, ид хавтай баатар эрийн алхаагаар урагш давшиж, шинэ бүхэн хөгжлийн баталгаа болон цэцэглэж байхад зохиолч Л.Бадарч энхрий хайрт эх орныхоо тэр их хөгжилд улам их тус болох хүслээр уран бүтээлдээ эрэл хийж, түүнийгээ зөвөөр сонгож олсон нь шог, хошин зохиол байлаа»¹ гэсэн байдаг. Л.Бадарчийн уран зохиол, нийтлэлийн ид цэцэглэлт нь Монгол оронд социалист нийгмийн үндсийг тавих шилжилтийн зорилтуудыг хэрэгжүүлэх үетэй давцаж байгаа нь түүний зохиол, нийтлэлийг хурц дайчин, цаашилбал нийтлэлийн арга барил, өнгө аяс давамгайл болоход нөлөөлсөн гэж үзмээр байдаг. Түүний «Дэндүү Дэндэв» өгүүллэгийн баатар нэгэн байгууллагын аж ахуйн нярав Дэндэв бол дүнзэн байшин нь дүүрэн боловч дүнхийсэн толгой нь хоосон, амин хувийн юм бол гурвалжин мод, гурван төгрөгийг ч хайрладаг атлаа, албаны юм болохоор алт ч байсан алхаад гардаг, торго ч байсан тосдоод хаядаг хүн юм. Үүнийг зохиогч дүрслэн үзүүлэхдээ «Найман жил өмссөн нарийн цагаан эсгий гутал, арван жил хэрэглэсэн герман дугуйгаа аминаасаа илүү хайрладаг Дэндэв өөрийнхөө хуучин ямаан дахнаас ширхэг үс унахад яс бутарч, мах тасарсан шиг харамсаж байдаг боловч, сангийн шинэ ямаан дахаар шавардсан гутлаа арчиж, аминыхаа хоёр гэрийг зэвэрсэн зуухтай нандигнан хураасан мөртөө албаны гэрийг зунжин барьж, шинэ зуухыг нь гадаа галлан зэврүүлж, хувийнхаа хашаа байшинг арцсан толь шиг гялалзуулдаг байтлаа аж ахуйнхаа бараа таваарыг шалбааг ус гатлах дамнуурга болгон тавьсан» баримтаар илчлэн харуулсан байна.

Л.Бадарчийн «Чулуун арслангийн хэрэг» өгүүллэг шинэ нийгмийн хүний

хүмүүжил, ёс суртахууны дэвшил, хоцрогдлыг үйл явдлын маш нарийн уялдаагаар нэн уран тод илэрхийлсэн зохиол юм. Өгүүллэгийн баатар Пунцаг, Тунсаг хоёр нийгмийг үзэх үзлээрээ тэс ондоо боловч, олж долохын шуналаараа нэг тэрэгний хоёр дугуй мөн ажээ. Тунсаг нь хуучны юм бүхнийг өргөмжлөн магтаж, өнөөгийн амьдралыг буянаа барсан мэтээр үгүйсгэж байхад, Пунцаг нь хуучны юм бүхнийг феодалын хэмээн харааж хувьсгалчийн дүр эсгэж явдаг нэгэн юм. Тэд энэ ерөөсгөл үзлийнхээ уршгаар эцэстээ олон нийтэд тараа таниулж, өөдлөх амьдралын өргөс болж хоцорчээ. Үүнийг зохиогч «Чанцал чавганцын жил орж өвчлөхөд нэг нь гүрэмч, нөгөө нь төлөгчөөр ирж, ам хэлээрээ гал ус шиг зөрөөтэй байснаа амьдралын адагт нэгэн урсгалд нийлж» байгаагаар үзүүлсэн байна. Энэ бүхний цаана амьдралын эрээн барааныг олж харж, онож хэлдэг зохиогчийн авьяас, хөдөлмөр тодорхой харагдана.

Үүнээс гадна хот, хөдөөгийн албан газруудад ажилладаг хүнд сурталтнуудыг шоглон шүүмжилсэн «Суудаг, гүйдэг хоёр» (1954), «Лхаа таван тэнгэр» (1956) зэрэг өгүүллэгийг тооцож үзвэл нийгмийн хөгжилд саад бологч арчаагүй хоцрогдлын дүр зураг улам ч тод харагдана. «Суудаг, гүйдэг хоёр» өгүүллэгийн баатар Шуурхай ажлын цагаар «Найман тасалгааг нааш цааш сүлжин Найдангийн тушаал дэвших гэж байгаа, Намсрай амралтаа авах гэж байгаа, Дамбын найр маргааш болох, даргын машин хээр суусан, цалингийн цэс бэлэн болсон, Цамбын эхнэр жирэмсэн байгаа»-г мэдсэнээрээ бүхнийг амжуулагчийн дүр үзүүлж, үндсэн ажлаа хийдүүлж байгаа бол, Суурь нь суудлаасаа ховхролгүйгээр «Албан

мэдээ шаардаж, арван удаа утасдаад, ам заавар өгөх гэж тав дахин утасдаад, арваад папирос баагиулж, албан тасалгааг униартуулж» сууна. Өгүүллэгийн хоёр баатар өөр өөр арга барил, ааш араншинтай хүмүүс боловч, аль аль нь нийгмийн хөгжлөөс хойш чангаагчид юм. Зохиогч өгүүллэгийнхээ баатруудад Шуурхай, Суурь гэдэг нэр өгсөн нь ч дүрийн ялгарлыг гаргахад тустайн дээр шог, хошин өнгө аясыг буй болгосон оновчтой шийдвэрлэл болсон юм. Л.Бадарчийн унаган авьяас, уран бүтээлийн нарийн мэдрэмж, сэтгэлгээг мэргэжил нэгт нөхөд нь үнэлж «Төрөлх хэл бичгийн шилдэг сайн боловсролтой, билэг авьяастай, цэцэн цэлмэг ухаантай энэ хүн шог, хошин зохиол бичих болсноороо нам, ард түмнийхээ үйл хэрэгт тус хүргэж, эх орныхоо утга зохиолд шог, хошин зохиолыг хөгжүүлэгч том мастериин ёсоор алдаршжээ»² гэсэн удаатай.

Л.Бадарч «Лхаа таван тэнгэр» өгүүллэгтээ хөдөө нутгийн нэгэн албан хаагч Лхаасүрэн гэгч «Би гэдэг чинь хэн бэ? Одоогийнхоор бол гавьяатай, урьдынхаар бол буянтай хүн дээ. Албан тушаал гэвэл байна, адуу мал гэвэл байна. Бас талтай нүүртэй, талын чинээ хүн дээ» хэмээн хаахалзаж, түүнийгээ «бүхнийг чадах ид шид, ивээх тэнгэр» хэмээн итгэж улсын ажлыг цалгардуулж байгааг уран тод дүрсэлсэн юм. Ер нь Л.Бадарчийн өгүүллэг, найрууллуудад улс нийгмийн хөгжлийн төлөө үнэнчээр зүтгэхийн оронд албан тушаал, ашиг хонжооны хойноос хөөцөлдөгчдийг голчлон шүүмжилсэн байдаг нь түүний иргэнлэг үзлийн илэрхийлэл болдог юм.

Л.Бадарч шог найрууллын том төлөөлөгч байв. Нийтлэлийн онолчид «Шог найруулал нь нийтлэл-уран сайхны хосолмол шинжтэй зүйл болохын-

хоо хувьд амьдралын баримт, үзэгдлийг зайлшгүй нэгтгэн дүгнэж, уран сайхны дүр бүтээх зорилтыг агуулдаг. Өөрөөр хэлбэл шог найруулал нь шог өгүүллэг шиг уран сайхны шог, хошин дүр бүтээдэг боловч, уул дүр нь бодит хүн байдгаараа шог өгүүллэгээс ялгардаг³ гэж үздэг. Л.Бадарчийн шог найрууллууд бодит амьдрал, бодит хүний хоцрогдсон бурангуй явдлыг найрууллынхаа араг яс болгож, түүнийг тойруулан уран сайхны хийсвэрлэл бүхий сөрөг дүр бүтээдэг онцлогтой байна. Найрууллын их мастер гэгддэг Марк Эзрович Виленский «Нарийн нягтлан шалгасан хөдөлбөргүй баримтыг уран сайхны аргаар боловсруулахгүй бол олигтой шог найруулал болж чадахгүй. Уран сайхны аргаар боловсруулахын тулд шог най-

руулалч хүн жинхэнэ ажил хэрэг дээр болоогүй, байгаагүй, барагцаалсан хэтрүүллийг хэмжээ хязгаартай ашигладаг⁴ гэсэн билээ. Л.Бадарч бодит байдлыг хүний ой тойд өртүүлэх, сонирхлыг татах зорилгоор уран сайхны хийсвэрлэлийг чадамгай ашигладаг нийтлэлч байлаа.

Л.Бадарчийн бичсэн авсаархан хэмжээтэй, өвөрмөц өгүүлэмжтэй шог найруулал нь тус тусдаа оршин байгаа дутагдлыг онож буудсан мэргэн буучийн сум шиг хурц тусгалтай байдаг. Ийм бүтээлийн тоонд малын тэжээл бэлтгэх ажлаас хойш суугчийг жигшүүлсэн «Балдан, Галдан хоёр», их

барилгын ажлыг удаашруулагч хүнд сурталтныг шүүмжилсэн «Шинэ маягийн хиргис үүр», машин техникийн засварыг орхигдуулж, улсын хөрөнгийг сүйтгэгчдийг бут ниргэсэн «Хөх торгон хөнжил», нийгмийн хэв ёсыг гажуудуулагч балмад явдалтныг үзүүлсэн «Захын ганц модны учир», ариун цэврийн шаардлагыг хөсөрдүүлж, хот орчныг бохирдуулагчдыг буруушаасан «Хог бол хэрэм биш», ажил үүргээ хийдүүлж, ард иргэдийг хохироогчдыг зэмлэсэн «Ямар арга хэмжээ авах вэ?», хөгшин настай хүмүүсийг үл хүндлэгчдийг зэвүүцсэн «Ёстын ёсч гэгч нь», соёл хүмүүжлийн ажлаас хойш сууж, доош малтагчдыг хашраасан «Мягмарын өвчин», төрөлх хэлээ буртгаж харь хэлээр шалиглагчдыг шоглосон «Амьд хүүхэлдэй», амин ху-

«

*Л.Бадарч Монголын сэтгүүл зүйд
хоцрогдонгуй байсан шог, хошин
нийтлэлийг хөгжүүлэхэд
гүйцэтгэсэн үүргээрээ бусдаас
онцгойрч байжээ. Шог, хошин
нийтлэлд тусган үзүүлж байгаа
зүйлдээ тохирсон санааг тод
томруун гаргаж, үйл явдлыг уран
сайхны хэтрүүллийн хэрэглүүрээр
чимэглэж сонирхолтой болгох
аргыг өргөн хэрэглэдэг нь түүний ур
чадварын нэг онцлог юм.*

»

вийн эрх ашгийг нийгмийн эрх ашгаас дээгүүр тавигчдыг элэглэсэн «Цалинтай малгай», үйлдвэрийн бүтээгдэхүүнд гологдол гаргаж, хөрөнгө материал сүйтгэгчдийг түншсэн «Зовлонтой тоглоом» гэх зэрэг олон арван өгүүллэг, найрууллыг нэрлэж болно.

Л.Бадарч Монголын сэтгүүл зүйд хоцрогдонгуй байсан шог, хошин нийтлэлийг хөгжүүлэхэд гүйцэтгэсэн үүргээрээ бусдаас онцгойрч байжээ. Шог, хошин нийтлэлд тусган үзүүлж байгаа зүйлдээ тохирсон санааг тод томруун гаргаж, үйл явдлыг уран сайхны хэтрүүллийн хэрэглүүрээр чимэглэж сонирхолтой болгох аргыг өргөн

хэрэглэдэг нь түүний ур чадварын нэг онцлог юм. Ялангуяа хомхой сэтгэлтэн, арчаагүй хоцрогдол, араатан шинжтэний нүүр царайг илчлэхдээ шинэ хүний сэргэлэн хараа, саруул ухааны гойд чадлаар элэг хөштөл инээлгэж, нүд хорстол жигшүүлэхүйц дүрсэлсэн нь олонтаа тааралдана. Утга зохиолын шүүмжлэгч Д.Цэндийн дүгнэсэнчлэн түүний нийтлэл, зохиолд «Сайн муу хоёр баатрыг хооронд нь, нэг хэрэг явдлыг нөгөөтэй нь харьцуулан, түүний улмаас эерүү ба эсрэг талыг хурц заагтай дүрсэлсэн нь талархал, жигшлийг төрүүлэх зохиолын урлагт сайнаар нөлөөлсөн»⁵ байна.

Шог найруулалд дутагдал доголдлыг хурцаар шүүмжилж, улмаар засч залруулах зорилтыг урьдал болгодог бол, хошин нийтлэлд уран ёгт элэглэл, шоглолыг илүүд үздэг. Аль аль нь нийтлэл-уран сайхны бүтээлийн эрхэм нандин шинж мөн. Сэтгэл хөдөлгөм инээлгэж, дутагдлыг илрүүлэн жигшүүлэх гэдэг бол уншигчаас үйл хэргээ эргэн харж ухаарах хүчирхэг зэвсэг мөн билээ. Тиймээс ч Оросын их зохиолч Н.Гоголь «Инээд бол ертөнц дээр юунаас ч айдаггүй хүнийг ч айлгагч мөн» гэсэн байдаг. Энэ үүднээс үзвэл Л.Бадарчийн шог, хошин нийтлэл уншигчийг инээлгэхийн хамт хүмүүсийн үзэл санаа, үйл ажиллагаанд байгаа хуучирсан бодол, хоцорсон арга барилыг мэргэн онож, шинэ хуучны зөрчлийг тод томруун харуулдгаараа үнэхээр айлгагч зэвсэг болж чаддаг онцлогтой ажээ. Залуу судлаач, доктор (Ph.D) Н.Мөнхзориг Л.Бадарчийн шог, хошин нийтлэлийг судалж үзээд «Түүний бичсэн бүх шог зохиолыг нэг мөр уншсаны дараа энэ хүн манай нийгэм болон хүмүүсийн амьдралд амь бөхтэй зууралдаж үлдсэн хоцрогдсон дадал

заншил, үзэл санааны чухам юуг нь шүүмжилж шоглолгүй орхигдуулсныг бодож олоход бэрх. Сэтгэлд сэвтэй, нүдэнд эвгүй үзэгдсэн ямар ч дутагдлын дэргэдүүр жижиг гэлгүй зүгээр өнгөрч байсангүй. Ямар нэг зүйлийг шүүмжлэх болохоор түүнийг шог, хошин аль хэлбэрээр, чухам яаж үзүүлэх вэ, яаж түүнийгээ аль болох олон хүнд хүртээмжтэй хүргэх вэ, түүнд тохирох ямар үгийг хэрэглэх вэ гэдгийг шийдэхдээ ч ардынхаа баян тансаг хэлний үгийн санг шүүрдэн маш их эрэл хийдэг нь Л.Бадарчийн зохиол бүтээлээс харагддаг»⁶ гэсэн бол, доктор (Sc.D) Г.Дэлэг «Л.Бадарч авьяас билэг, уйгагүй хөдөлмөрч чанар, боловсрол мэдлэгээ шог, хошин зохиолын хэлбэр, агуулгыг баяжуулах, зохиомжийг сайжруулахад чиглүүлж... цагаа олсон, сонирхолтой олон чамбай зохиол туурвиж байснаараа манай сэтгүүлч нарт хичээл сургамж, бүтээлч туршлага болох өвийг үлдээсэн шог зохиолч, авьяас төгөлдөр томоохон сэтгүүлч байлаа»⁷ гэсэн нь зүй ёсны үнэлэлт юм.

Л.Бадарчийг бас улс төрийн шогийн их чадвартан гэж үзэхээс өөр аргагүй юм. Шог зохиол, нийтлэлийн хамгийн хурц дайчин хэлбэр болсон улс төрийн шог бичихэд зохиогчоос асар их мэдлэг, авьяас шаарддаг. Л.Бадарч дөчөөд оны сүүл хэрд бичсэн «Самурайн шинэ эзэд», «Уйлах, инээх», «Америкийн зүүд ба алтан загасны үлгэр», «Хазгар илжигний түүх», «Чонын найзлал», «Худгийн мэлхий» зэрэг улс төрийн шогтоо дэлхий дахиныг дээрмийн аргаар эзэгнэж хагартлаа баяжих, энэ санаархлаа хэрэгжүүлэхийн тулд яахаас ч буцахгүй байгаа эзэд, дайны хэнээтнүүдийн үнэн нүүр царайг гашуун инээд, уран хурц элэглэлийн аргаар илэрхийлсэн байдаг.

Л.Бадарч «Самурайн шинэ эзэд» улс төрийн шогтоо дайны хэнээтнүүдийн дүр төрхийг харуулжээ. Токио хотын цэргийн нэг эмнэлэгт өвчиндөө солиорон хэвтэж байгаа самурай улс төрийн шогийнх нь гол баатар юм. Тэр самурай Хасан нуурын байлдаанд нэг хөлөөрөө амиа сольж авсан бөгөөд эцэст нь 1945 онд ганц гараа өргөж байж амьд үлдсэн, харгис хэрцгийгээрээ жирийн япон хүмүүст жигшигдсэн этгээд юм. Түүнийг гудамжинд "дайн зайлшгүй" хэмээн хашгирч хэвтэхэд нь Америкийн согтуу цэргүүд "энэ хэрэгтэй сайн хүн байж мэднэ" гэж бодоод эмнэлэгт авчирсан ажээ.

- Аа, та нар чинь америкчууд юм уу? Их наран Япон улсын колони Америкийн иргэд үү? ...Манай Их наран улс Америк улсад хүрэх их урт олс томжээ. Тэр олсоороо америкчуудыг оосорлож амжжээ. Оо, их сайн хэрэг гэж инээхэд, америк эмч солиорогч самурайн гарыг шүүрэн аваад тарилга хийх зуураа,

- Та тэсвэрлэж үз. Тэр урт олсыг та нар томж амжаагүй. Харин манай Америкийн эрхэм ноёд Нью-Йоркоос Токио хүрэх урт олс татсан. Түүгээрээ та нарыг оосорлож авсан... Манай америк ноёд бүх дэлхийг оосорлож болох урт олс томох гэж туршиж байна. Энэ хэргийг бүтээхэд та болон таны баатарлаг самурай нар бидэнд хэрэгтэй байна. Халхын гол, Хасан нуурт яаж Их наран эзнийхээ төлөө зүтгэсэн шигээ дэлхийн ямар нэг гол, ямар нэг нуурын тэнд, манай Уолл-стритийн эрхмүүдийн төлөө та зүтгэх болно гэхчилэн ярилцаж байгаагаар эзлэн түрэмгийлэгчид зүс царай өөр, газар нутаг ондоо боловч шунахай сэтгэл нь адилхан байдгийг жишин харуулсан оновчтой өгүүлэмж болсон байна. «Улс төрийн шогийн онцлог нь ширүүн мэтгэлцэл, егөөдөл, энгүүхэн үг

хэлтэй байхын хамт "баатрын" бузар булай явдлын талаар уншигчдад зэвүүцэх, үзэн ядах, дургүйцэх сэтгэл төрүүлэх явдал мөн»⁸ гэж нийтлэлийн онолчид үздэг. Л.Бадарчийн улс төрийн шогт дайрч ёжилсон, ингүүн үг хэллэгийг түгээмэл хэрэглэсэн байхын зэрэгцээ, егөөдөл, хэтрүүлэл зэрэг шоглолын хэрэглүүрийг өргөн ашигласан байдгаараа онцлогтой юм.

Л. Бадарч «Худгийн мэлхий» улс төрийн шог зохиолдоо ардын аман зохиолын хэлбэрийг ашиглан ардын ёгт үлгэрт гардаг худгийн мэлхийн дээрэнгүй, тэнэг бүдүүлэг шинжийг үлгэр болгож, гадаад далайгаас ирдэг мэлхийн оронд энх тайвны тагтаа шувууг айлчин болгож, тэдний яриагаар дайн өдөөгчдийн тэнэг бодол, энх тайвны их хүчийг харьцуулан дүрсэлжээ. Гол санаа нь дайн өдөөгчдийн хүч худгийн ус шиг явцуухан байхад, энх тайвны хүч гадаад далайн ус шиг арвин юм гэдгийг тунхаглан зарласан байна. Тиймээс ч зохиогч улс төрийн шогийнхоо санааг зангидаж "Шинэ дайны эсрэг энх тайвны хүч нь ширгэсэн худгийн дэргэд далайн ус шиг арвин юм" хэмээн өгүүлсэн байдаг. Л.Бадарчийн «Хазгар илжигний түүх» улс төрийн шогт ашиг олз хайсан америк ноён хар илжгээ эцээж арай чамай гэж Англи оронд ирээд гэнэтхэн тэнэг ноёнттой учирч, улмаар гэрт нь хонож байна. Худалдаачин америк орой бүрий болоход өлссөн муу илжгэндээ өвс өгөх зуур бөөн хэсэг долларыг бөгс рүү нь хийчихээд, миний илжиг доллараар баадаг хэмээн англи ноёнд үзүүлсэнд тэр ноёны шунал нь хөдөлж, хамаг мөнгөө цөлмөж байж хазгар илжгийг авдаг. Шидэт илжгэнд идэх юм өгвөл гарах доллар нь бас гарцаагүй нэмэгдэнэ гэж америк худалдаачны

захисан ёсоор англи ноён илжгээ арьсыг нь хагартал бордож, хар илжигнийхээ бөгс рүү харан харан суувч магтаалт илжигний түүх Маршаллын төлөвлөгөөтэй адил болж, долоон жил хүлээвч доллар ер гараагүй⁹ тухай өгүүлдэг. Энэ шог хэдийгээр уран сэтгэмжээр бичигдсэн боловч олз ашиг хайгчдын хүний үнэргүй цэвдэг сэтгэл, хорон муу заль мэхийг уран элэглэл, ёгтлолын аргаар харуулан, аль ч газрын баяд, ноёд цөм адилхан эрээ цээрээ алдсан хүмүүс гэдгийг үзүүлснээрээ нийтлэлийн хурц шинжийг агуулж байгаа юм.

Л. Бадарч шог, хошин нийтлэлдээ дотоод мөн чанар, гадаад хоосон овор төрх хоёрын зайлшгүй зөрчил хурцадсан тэр агшин буюу амьдралын хуучирсан дадал хэвшлийн утга учиргүй байдал, түүнээс гарах муу үр дагаврыг соргог ажиг, хурц дүрсэлдэг нийтлэлч, зохиолч байв. Тэр нь эрин цагийн шинэ хүний гэгээн саруул инээдээр эсрэг баатрын дүрийг төлөөлүүлж, цаг үеэ олсон асуудлыг ямагт дайчин хурц дэвшүүлж, уран нарийн, яруу тод зураглал, мэргэн цэцэн, гашуун хорон үг хэлээр илэрхийлж чаддаг зохиогчийн ур чадварын онцлогоор илэрч гардаг юм.

Л.Бадарчийн шог, хошин нийтлэл, зохиолыг нэгтгэн дүгнэж үзэхэд тэрбээр юуны өмнө хувьсгалын ардчилсан шатны зорилтыг хэрэгжүүлж, улмаар улс оронд социалист нийгмийн үндсийг тавих түүхэн зорилтыг шийдвэрлэж асан дөч, тавиад онд хүн ардын ухамсар, хүмүүжилд хуучин нийгмээс үлдэж хоцорсон дутагдал ихээхэн саад болж байгааг соргог мэдэрч, тэрхүү хоцрогдлыг үгийн урлагийн хүчээр засч залруулахад хамаг авьяас мэдлэгээ зориулж байсан нь харагдана. Өөр

үгээр хэлбэл түүний нийтлэл, зохиол бүхэн цаг үеэ тусгаж, эх орон, хүн арддаа тус болоход чиглэсэн байдаг. Энэ зорилтоо хэрэгжүүлэхдээ тэрбээр амьдралын мэдлэг туршлага, ажигч гярхай чанар, төрмөл их авьяасаар зодож, уран бүтээлээрээ хүний сэтгэлийг татаж, ухааруулан сэнхрүүлэх ид шидийг олж чадсан байна. Амьдралын мэдлэг туршлага, ургуулан бодох чадвар, авьяас чадварыг хамгийн их шаарддаг ярвигтай төрөл, зүйл болох шог хошин зохиол нийтлэлийг сонгон авч, нэгэн цаг үеийн нэрт төлөөлөгч болтлоо өсч дэвжсэн нь түүний сэтгүүлчийн үйл ажиллагааны онцлог мөн.

Ишлэл

¹ Цэнд Д. 1984. Зохиолчийн уран бүтээлийн тухай. УБ., 24 дэх тал.

² Бааст Б. 1962. «Лувсандашийн Бадарч» өгүүлэл // Л.Бадарч. Зохиолууд. УБ., 8 дахь тал.

³ Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ., 258 дахь тал.

⁴ Виленский М.Э. 1982. Как написать фельетон. М., с. 25, 36.

⁵ Цэнд Д. 1984. Зохиолчийн уран бүтээлийн тухай. УБ., 31 дэх тал.

⁶ Мөнхзориг Н. Монголын шог, хошин нийтлэлийн уламжлал, шинэчлэл. Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ., 77 дахь тал.

⁷ Дэлэг Г. 1972. Монголын хэвлэл. I боть. УБ., 315 дахь тал.

⁸ Богданов Н. Г., Вяземский В. А. 1971. Справочник журналиста. М., с. 289.

⁹ Бадарч Л. 1956. Түүвэр зохиол. УБ., 147-149 дэх тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Бааст Б. 1962. "Лувсандашийн Бадарч" өгүүлэл // Л.Бадарч. Зохиолууд. УБ.

2. Бадарч Л. 1956. Түүвэр зохиолууд. УБ.

3. Дэлэг Г. 1972. Монголын хэвлэл. I боть. УБ.

4. Мөнхзориг Н. 2012. Монголын шог, хошин нийтлэлийн уламжлал, шинэчлэл. УБ.

5. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.
6. Цэнд Д. 1984. Зохиолчийн уран бүтээлийн тухай. УБ.
7. Юмсүрэн Т. 1969. Л.Бадарчийн шог хошин зохиолын тухай // «Багш, оюутны эрдэм шинжилгээний бичиг». УБ.
8. Богданов Н. Г., Вяземский В. А. 1971. Справочник журналиста. М.
9. Виленский М.Э. 1982. Как написать фельетон. М.

Резюме

В настоящей статье автор путём семантического анализа публикаций

Л.Бадарча предприняла попытку доказать, что он являлся крупнейшим представителем сатирической журналистики Монголии 40-50-х гг. прошлого века и талантливым сатириком. Автор на основе анализа тематики, содержания и жанра сатирических и юмористических публикаций Л.Бадарча пришла к выводу, что он являлся журналистом, умевшим "зреть в корень", способным исправлять критикой человеческие и социальные недостатки, которые в скрываются в отношении к труду, нравственных устоях, и стремившимся устранить препятствия, которые тормозили развитие и процветание страны.